



# СОЁМБО МЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№95 (95)

2021.07.21

## ЦАХИМ ШУУДАНД

### ТӨРИЙН ОДОН МЕДАЛЬ ГАРДУУЛЖ ЦЭРГИЙН БАГИЙН БИЕ БҮРЭЛДЭХҮҮНЭЭ ХҮЛЭЭН АВАВ

Зэвсэгт хүчний 350 дугаар анги



Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2021 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн А/322 дугаар тушаалыг үндэслэн ангийн захирагчийн тушаалаар тус ангиас нийт 150 цэргийн алба хаагч 6 дугаар сарын 24-ний өдрөөс 7 дугаар сарын 09-ний өдрийг хүртэл Тулгар төрийн 2230 жил, Их Монгол Улсын 815 жил, Ардын хувьсгалын 100 жил, Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах ажилд дэмжлэг үзүүлэн ажиллаа.

Баяр наадмын өдрүүдэд үзэгчдийн хүртээл болсон "Би Монгол хүн" теле концертын зураг авалт, бэлтгэл ажилд тус ангиас нийт 160 гаруй цэргийн алба хаагчид удирдлага, бүтээн байгуулалт, тохижилт, уран сайхны бүлгүүдэд ажилласан юм. Тухалбал МУГЖ Т.Ариунаа, Б.Сарантуяа, С.Жавхлан, Г.Ариунбаатар, СТА Х.Уламбаяр, Г.Алтаншагай, А.Хишигдалай, Б.Зоригт, Н.Баярцэнгэл,

Ч.Бадамханд зэрэг дуучид, Хурд, Харанга хамтлагуудын дуунд олны хэсгийн зураг авалтад оролцлоо.

Мөн Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн ахлах ахлагч Э.Даваажамцыг налайх дүүргээр дамжин өнгөрөхөд хүлээн авч хүндэтгэл үзүүлэхийн зэрэгцээ бие бүрэлдэхүүний дунд уриалга гарган мөрдөс нэгт дайчин нөхрийнхөө эр зориг, тэсвэр хатуужлыг өндрөөр үнэлэн амжилт хүсэж сэтгэлийн дэм үзүүлж 350,000

төгрөгийн хандивыг цуглуулсныг гардуулан өглөө. Мөн энэ сарын 19-нд Төрийн одон медаль гардуулах, Зэвсэгт хүчинд Цэргийн холбоо үүсэн байгуулагдсан 100 жилийн ойн медаль, Исламын Бүгд Найрамдах Афганистан Улсад явагдсан олон үндэстний ажиллагаанд үүргээ амжилттай гүйцэтгээд ирсэн алба хаагч нарыг хүлээн авч хүндэтгэл үзүүлэх ажиллагааг тус тус зохион байгуулан явууллаа.

Ахмад Б.ДЭРДЭНЭНИНЖ

### БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АЖЛЫГ ЭХЛҮҮЛЭЭ

Зэвсэгт хүчний 325 дугаар анги



Батлан хамгаалах яамны 110 жил, Зэвсэгт хүчний 100 жилийн түүхт ойнудыг тохиолдуулан Завхан нутгаас төрсөн генерал цолтнуудыг алдаршуулах тэдэнд зориулсан хүндэтгэлийн талбайг шинэчлэн өнгө үзэмжийг сайжруулах зорилгоор бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлээд байна. Бүтээн байгуулалтын ажилд Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн бие бүрэлдэхүүн 2.445.000 төгрөгийг хандивласныг өнгөрсөн даваа гарагт Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн Захирагчийн орлогч захиргааны удирдлагын

тасгийн дарга, дэд хурандаа П.Мэндбаяр тус бүтээн байгуулалтын ажлын хэсгийн дарга, Завхан аймгийн Цэргийн хэлтсийн дарга, хурандаа Г.Үнэнбаярт гардуулан өгч ажилд нь амжилт хүслээ.

Мөн Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн бүрэлдэхүүн бүтээн байгуулалтын ажлыг гардан гүйцэтгэж байгаа юм. Завхан аймаг үүсэн байгуулагдсанаас хойш Монгол төрийн генерал цолтон 24 буюу Монгол улсын хэмжээнд хамгийн олон генерал цолтон төрсөн аймаг юм.

### АМЬДРАЛ БЭЛЭГЛЭЭ, ХАРИУ НЭХЭЭГҮЙ ТУС

Зэвсэгт хүчний 353 дугаар анги

Ангийн бие бүрэлдэхүүн "Амьдрал бэлэглээ", "Хариу нэхээгүй тус", "Донор Та баатар", "Дусал Цус нэг амь" зэрэг өдөрлөгүүдэд тасралтгүйгээр 3 дахь жилдээ нэгдэж цусаа хандивлаж байна.

Цус бэлэглэх өдөрлөгийн хүрээнд Зэвсэгт хүчний 353 дугаар ангийн 100 гаруй офицер, ахлагч, ажилчин алба хаагчид халдвар хамгааллын дэглэмийг баримтлан, өмнөх жилүүдийнхээс илүү идэвхтэй оролцлоо.



## МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН	ЭДГЭРСЭН	НАС БАРСАН
149,773 +1319	137,602 +3501	745 +5

## ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ	ЭДГЭРСЭН
3895 +67	252 +17	3574 +25

## КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол	Нийт: 192,215,741
Эдгэрсэн	Нийт: 174,915,658
Нас барсан	Нийт: 4,133,136

Хэрэв Та бие тань тавгүйрсэн эсвэл гэртээ тусгаарлагдаж байгаа бол энэ нэгэнтэй уулзахаас татгалзаарай. Ингэснээр Та халдварын гинжин хэлхээг таслахад чухал үүрэг гүйцэтгэнэ.



ТАНЫ БИЕ ТАВГҮЙ БАЙВАЛ  
ГЭРЭЭСЭЭ БИТГИЙ ГАРААРАЙ!

## ЗУРХАЙ

Билгийн тооллын 12  
2021.07.21 /ЛХАГВА ГАРАГ/

**ЗУНЫ АДАГ ХӨХӨГЧИН ХОНЬ  
САРЫН ДӨРВӨН НОГООН  
МЭНГЭТЭЙ ЦАГААН МОРЬ  
ӨДӨР**

Үс засуулбал:

Өвчин эмгэг ирнэ

Наран ургах, шингэрх:

05:15-20:42

Барилдлага:

Идэр

Шүтэн барилдлага:

Хүрэлцэхүй

Суудал:

Төмөр

Энэ өдөр гахай, хулгана, үхэр, луу, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой.

Эл өдөр баяр баясгалангийн хурим үйлдэх, шинэ гэр барих, хувцас өмсөх, чимэг зүүх, бүжиг наадам үүсгэхэд сайн, хараал дарах, гал мандал хий зэрэгт сайн. Баруун нүд татвал эд олох, баруун чих хангинавал аймшиг болох, зүүн чих жингэнэвэл жуулчин ирэх, хэрээ дуугарвал зочин ирэх, тагнай загатанал амгалан болох, бие татвал эцэг эх цочих, хөл татвал тэмцэл болно.

ЦАХИМ ШУУДАНД

ТОКИО-2020 олимпын наадамд оролцох “Алдар” спорт хорооны тамирчдыг цувралаар танилцуулж байна.

“АЛДАР” СПОРТ ХОРООНЫ ТАМИРЧИН МУГТ, АХЛАХ ДЭСЛЭГЧ МӨНХЖАНЦАНГИЙН АНХЦЭЦЭГ



МУГТ, Ахлах дэслэгч М.Анхцэцэг нь 1997 оны 12 дугаар сарын 25-нд Улаанбаатар хотод төрсөн.  
- 2003-2013 онд нийслэлийн Хан-Уул дүүргийн Ерөнхий боловсролын 114 дүгээр дунд сургуулийг төгсөж, бүрэн дунд боловсрол эзэмшсэн.  
- 2014 оноос БХЯ, Зэвсэгт хүчний “Алдар” спорт хорооны Их спортын албаны Техник хэрэгслийн спортын бүлгийн тамирчнаар томилогдон дараах амжилтуудыг гаргаад байна.

Монгол Улсын 9 удаагийн аварга бөгөөд Монгол Улсын дээд амжилтын 70 гаруй удаа шинэчлэн тогтоогоод байгаа энэ цаг үеийн шилдэг тамирчин юм

АМЖИЛТЫН ТОВЧООН

- 2009 онд “Монголын хүндийн өргөлтийн холбоо”-ны ерөнхийлөгчийн цомын тэмцээнээс хүрэл медаль  
- 2010 онд насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнээс хүрэл медаль  
- 2010 онд залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээнээс алтан медаль  
- 2011 онд Монголын хүүхэд залуучуудын 4 дүгээр их наадмаас алтан медаль  
- 2011 онд насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнээс алтан медаль  
- 2012 онд Монголын Бүх Ард Түмний 13 дугаар спортын их наадмаас алтан медаль  
- 2012 онд Тайланд улсад зохиогдсон “Эзэн хааны цом”-ын тэмцээнээс алт, мөнгөн медаль  
- 2012 онд залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээнээс алтан медаль  
- 2012 онд өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээнээс алтан медаль

тэмцээнээс алтан медаль  
- 2012 онд өсвөр үеийн Ази тивийн аварга шалгаруулах тэмцээнээс мөнгөн медаль  
- 2013 онд өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээнээс алтан медаль  
- 2013 онд залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээнээс мөнгөн медаль  
- 2013 насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнээс алтан медаль  
- 2013 онд “Үнэн анд” ХХК-ний нэрэмжит тэмцээнээс алтан медаль  
- 2013 онд оюутны улсын аварга шалгаруулах тэмцээнээс алтан медаль  
- 2013 онд О.Батсайханы нэрэмжит тэмцээнээс алтан медаль  
- 2014 онд өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээнээс алтан медаль  
- 2014 онд өсвөр үеийн Ази тивийн аварга шалгаруулах тэмцээнээс мөнгөн медаль  
- 2014 онд залуучуудын Ази тивийн аварга шалгаруулах тэмцээнээс хүрэл медаль  
- 2014 онд залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээнээс алтан медаль  
- 2014 оны насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнээс алтан медаль  
- 2014 оны оюутны улсын аварга шалгаруулах тэмцээнээс алтан медаль  
- 2014 онд “Нанжин-2014” залуучуудын олимпоос шагналт 4 дүгээр байр  
- 2014 онд насанд хүрэгчдийн Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс 9 дүгээр байр  
- 2015 онд “Монголын хүндийн өргөлтийн холбоо”-ны ерөнхийлөгчийн цомын тэмцээнээс алтан медаль  
- 2015 онд насанд хүрэгчдийн Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс 8 дугаар байр эзэлсэн.  
- 2016 оны насанд

хүрэгчдийн Ази тивийн аварга шалгаруулах тэмцээнээс алтан медаль,  
- 2016 оны Залуучуудын Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс алтан медаль,  
- 2016 оны МБАТ-ний 14 дүгээр их наадмын 3 алтан медаль тус тус хүртсэн.  
- 2017 оны Азийн өсвөр залуучуудын аварга шалгаруулах тэмцээнд 1-р байр  
- 2017 оны “Ашгабат 2017” Азийн танхимын наадмын 1-р байр  
- 2017 оны Насанд хүрэгчдийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд 3-р байр  
- 2019 оны Насанд хүрэгчдийн азийн аварга шалгаруулах тэмцээнд 2-р байр  
- 2019 оны Насанд хүрэгчдийн азийн аварга шалгаруулах тэмцээнд 3-р байр  
- 2019 оны Насанд хүрэгчдийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд 3-р байр  
- 2019 оны San-diego дэлхийн цомын тэмцээнээс алтан медаль  
- 2019 оны 12 сард Qatar сир Дэлхийн цомын тэмцээнээс хүрэл медаль  
- 2020 оны 2 сард АНУ-д болсон Дэлхийн цомын тэмцээнээс мөнгөн медаль тус тус хүртсэн амжилтуудыг гаргаад байна.

М. Анхцэцэгийн хувьд өнөөдөр Монгол Улсын багийн хоёрдугаар хэсэг болох 71 хүний бүрэлдэхүүнтэй хамт “Токио 2020” оролцохоор арлын орныг зорьж байгаа бол Монголын жүдо бөхийн үндэсний шигшээ багийн тамирчид хэдий очсон байгаа юм.  
Сонируулахад Токио 2020 зуны 32 дахь олимпын наадам өнөөдөр /2021.07.21/ хөлбөмбөг болон софтболын төрлүүдээр эхэлж байна. Энэ удаагийн олимпод 206 улсын 11 мянга гаруй тамирчид 33 спортын 339 багц медалийн төлөө хурд хүч, авхаалж самбаа, тэсвэр тэвчээрээ сорин оролцож байгаа юм.



ЦАГ ҮЕ

ШИНЖИЛГЭЭНИЙ ЦЭГҮҮДИЙН АЖИЛЛАХ ХУВААРЬ

Коронавируст халдвар илрүүлэх шинжилгээний цэгүүдийн наймдугаар сарын 15-ныг хүртэлх хуваарийг танилцуулж байна. Нийслэлийн зургаан дүүрэгт байнгын болон явуулын цэгүүд 09:00-12:00 хүртэл ажиллана.



НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ КОМИСС



2021.07.19-НӨӨС 2021.08.15-НЬ ӨДРҮҮДЭД АЖИЛЛАХ ШИНЖИЛГЭЭНИЙ БАЙНГЫН БОЛОН ЯВУУЛЫН ЦЭГ

№	Дүүрэг	Шинжилгээ хийх газар	Байршил	Ажлын өдөр	Бямба	Ням
1	Баянгол	96-р цэцэрлэг	3.4 дүгээр хорооллын эцэс, Говь сауны урд талд	Ажиллана	Ажиллана	
2	Сүхбаатар	143-р цэцэрлэг	Скайтел ХХК-ийн баруун урд талд	Ажиллана		Ажиллана
3	Чингэлтэй	50-р сургууль	Баянбүрд төвийн урд талд	Ажиллана	Ажиллана	
4	Баянзүрх	Шинжилгээ авах явуулын баг	Баянзүрх дүүргийн Авто оношлогооны төвийн зогсоол	Ажиллана		Ажиллана
5	Сонгинохайрхан	Шинжилгээ авах явуулын баг	5 шарын төмөр замын гарамын урд байрлах Номин агуулах байрны гадаа	Ажиллана	Ажиллана	
6	Хан-уул	Шинжилгээ авах явуулын баг	Буянт-Ухаа спорт цогцолборын гадаа талбай	Ажиллана		Ажиллана

ӨДӨР БҮР 09:00-12:00 ЦАГ ХҮРТЭЛ АЖИЛЛАНА

НИЙСЛЭЛИЙН НОГООН БҮСИЙН ОЙН САНГИЙН ШАВЖИЙГ УСТГАЖ БАЙНА



Нийслэлийн ногоон бүсийн ойн сангийн ойн хөнөөлт шавж, өвчний тархалтын судалгааг 80 мянган га талбайд хийхээр болсон. Судалгааны эхний тайлангийн үр дүнд нийт 2688 га талбайн шавжийг устгаад байна. Тодруулбал, агаарын хөлөг ашиглан микробиологийн аргаар 1938 га, механик аргаар 500 га, гэрлэн урхи тавих аргаар 250 га талбайн шавжийг устгалаа. Ойн санд тархсан ойн хөнөөлт шавж устгах ажлын гүйцэтгэчийг сонгон шалгаруулах нээлттэй тендерт “Сайхан ойн төлөө” ХХК шалгарсан бөгөөд ойн хөнөөлт шавжийг устгаж байна.

Эх сурвалж: НБОГ

ААДАР БОРООТой, 22-24 ХЭМ ДУЛААН БАЙНА

Нийслэлд үүлэрхэг. Бага зэргийн дуу цахилгаантай аадар бороо орно. Салхи баруун хойноос секундэд 5-10 метр, борооны өмнө түр зуур ширүүснэ. Өдөртөө 22-24 хэм дулаан байна.

Малчид, иргэдийн анхааралд: Өнөөдөр нутгийн төв хэсгээр дуу цахилгаантай аадар бороо орох тул мөндөр, нөөлөг салхи, аянга цахилгаан, үер усны аюулаас сэрэмжтэй байхыг анхааруулж байна. 2021 оны 7 дугаар сарын 21-ний 08 цагаас 20 цаг хүртэл: Баруун аймгуудын нутгаар үүл багасна. Бусад нутгаар үүлэрхэг. Төвийн аймгуудын ихэнх нутаг, зүүн болон говийн аймгуудын нутгийн баруун хэсгээр бороо, дуу цахилгаантай аадар бороо орно.

Салхи төвийн аймгуудын нутгаар баруун хойноос, бусад нутгаар баруун өмнөөс секундэд 6-11 метр, борооны өмнө түр зуур ширүүснэ.

Хангай, Хөвсгөлийн уулархаг нутаг, Завхан голын эх, Хүрэнбэлчир орчим, Идэр, Байдраг, Эг, Үүр, Ерөө, Орхон голын хөндийгөөр 17-22 хэм, Хэнтийн уулархаг нутаг, Их нууруудын хотгор болон говийн бүс нутгийн баруун хэсгээр 28-33 хэм, говийн бүс нутгийн зүүн хэсэг, Дорнод-Дарьгангын тал нутгаар 32-37



хэм, бусад нутгаар 22-27 хэм дулаан байна.

Багануур орчмоор: Үүлшинэ. Бороо орохгүй. Салхи баруун өмнөөс секундэд 7-12 метр. 26-28 хэм дулаан байна. Тэрэлж орчмоор: Үүлэрхэг. Бага зэргийн дуу цахилгаантай аадар бороо орно. Салхи 22-нд нутгийн өмнөд хэсгээр секундэд 13-15 метр, бусад хугацаанд нутгийн зарим газраар борооны өмнө түр зуур ширүүснэ. Алтай, Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутаг, Хүрэнбэлчир орчим, Туул, Тэрэлж голын хөндийгөөр шөнөдөө 5-10 хэм, өдөртөө 19-24 хэм, говийн бүс нутгаар шөнөдөө 19-24 хэм, өдөртөө 30-35 хэм, бусад нутгаар шөнөдөө 13-18 хэм, өдөртөө 25-30 хэм дулаан байна.

2021 оны 7 дугаар сарын 22-26 хүртэлх цаг агаарын урьдчилсан төлөв  
22-нд төвийн аймгуудын нутгийн зүүн хэсэг, зүүн аймгуудын ихэнх нутаг болон говийн аймгуудын нутгийн зарим газраар, 23, 25-нд

нутгийн зарим газраар, 24-нд баруун аймгуудын ихэнх нутаг, төв болон говийн аймгуудын нутгийн зарим газар, зүүн аймгуудын нутгийн зүүн хэсгээр бороо, дуу цахилгаантай аадар бороо орно. Салхи 22-нд нутгийн өмнөд хэсгээр секундэд 13-15 метр, бусад хугацаанд нутгийн зарим газраар борооны өмнө түр зуур ширүүснэ. Алтай, Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутаг, Хүрэнбэлчир орчим, Туул, Тэрэлж голын хөндийгөөр шөнөдөө 5-10 хэм, өдөртөө 19-24 хэм, говийн бүс нутгаар шөнөдөө 19-24 хэм, өдөртөө 30-35 хэм, бусад нутгаар шөнөдөө 13-18 хэм, өдөртөө 25-30 хэм дулаан байна.

Дарга, ерөнхий редактор, хурандаа САНЖМЯТАВЫН ТӨМӨРХҮЯГ

ЦАХИМ ХАЯГ  
Батлан хамгаалах яам  
Зэвсэгт хүчний Жанжин штаб

ЦАХИМ ХУУДАС  
"Соёмбо" сонин

\* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.  
\* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.  
\* Тус сонин мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Оффцеруудын ордон Индекс: 10018  
Цахим шуудан: Soyombo@mod.gov.mn Утас: 70001029, 3412 (дотуур)